



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.ОДОНТУЯА ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

додл. 03. 27 № ХТТ/684
танай _____-ны № _____-т

**Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай**

Таны санаачлан боловсруулсан Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

008235096147

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэлд:

“ҮИ.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн санаачлан боловсруулсан Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн санаачлан боловсруулсан Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах саналыг хууль санаачлагчид уламжлахаар хүргүүлэхээр тогтов:

1.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар эрх бүхий байгууллагаас хэлмэгдэгчийг цагаатгасан шийдвэр гарсан бол түүнийг үндэслэн нөхөх олговрын нэхэмжлэл гаргах эрх үүсэх бөгөөд мөн хуулийн 13 дугаар зүйлд заасан хэмжээгээр нөхөх олговор олгохоор заасан.

Иймд хуулийн төслийн үзэл баримтлалд цагаатгуулах гомдол хүлээн авах хугацааг сунгахтай холбогдуулан ямар нэг зардал бий болохгүй гэж дүгнэлт гаргасан байгааг анхаарч, хуулийн төсөлтэй холбогдуулан гарах зардлын тооцоог бодитойгоор дахин хийж гүйцэтгэх шаардлагатай байна.

2.Цагаатгуулах тухай гомдлыг хүлээн авах хугацаа 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон бөгөөд уг хугацаанаас хойш хуулийн төсөл батлагдан хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд гаргасан өргөдлийг хэрхэн шийдвэрлэх талаарх шилжилтийн зохицуулалтыг тусгах нь зүйтэй.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР